

## ТОЛЬ АШИГЛАГЧДЫН АНХААРАЛД

1. Толь бичигт орсон толгой үгийг догол мөрнөөс цагаан толгойн дэс дараагаар тус тус үүр болгон, хэвлэлийн ажиллагааг хөнгөвчлөн хуучин монгол бичгийг уул үүр үгийн эцэст хадмалласнаас гадна толгой үгийг тод хар үсгээр (ОН); тайлбарыг цагаан үсгээр (жилийг дэс дараалан тэмдэглэхэд хэрэглэх үг); жишээг бичмэл цагаан үсгээр (*нэг мянга есөн зуун хорин нэгэн он; бичигт өн сар тавих; төрсөн он*); хэвшмэл хэллэг, хоршоо, холбоо үгийг жижиг тод хар үсгээр (онд орох) (он туулах); он туулах (малын үхэлгүй, урин дулаан болгох); заалт үгийг чигжээтэй цагаан үсгээр (урга мал, амьтан); ишлэл үгийг цагаан үсгээр бичиж дан хаалтад хийсэн (*он онд идээшиж олон жилд дассан нутаг, өдоогийн шинэ Монголын улаан туг бүрхсэн орон*) (Д. Нацагдорж); хуучин монгол хадмалыг мөн тод хар үсгээр

2. Тус толь бичигт орсон үгсийн утгыг товч тайлбарласан.

3. Зарим үгийн тайлбарын оронд утга ойролцоо үгийг бичсэнээс гадна бас ч тайлбарт нэмэлт болгож утга ойролцоо үгийг тавьсан нь бий. Жишээлбэл:

**МӨДХӨН** даруйхан, төдхөн, гараад холдоогүй; *мөдхөн ирнэ.*

ᠮᠥᠳᠬᠥᠨ

**ЗАВТАЙ** зав бий, зайтай, чөлөөтэй ... *зүбүс*

4. Зарим үгийн тайлбарын оронд эсрэг утгатай үгийг тавьсан.

Жишээлбэл:

**ЗӨӨЛӨН** хатуу ширүүн, хатан гэдгийн эсрэг утга ... *сүхлэн*

5. Зарим үгийг хэл зүйн аргаар тайлсан. Жишээлбэл:

**НИСЭЛТ** нисэх үйлийн нэр; *нисэлтийн хурд* *үхэлд*

**НИСГЭХ** нисэхийн үйлдүүлэх хэв, нисэхэд хүрүүлэх; *тагтаа нисгэх; онгоц нисгэх.* *үхэлд*

6. Дуудлага бичлэг адил боловч утга өөр үгсийг догол мөрнөөс бичиж ром тоогоор дугаарласан. Жишээлбэл:

**БОРШИХ I** шингэн юмны чаналт нь хэтэрснээс болж дэндүү хурц амттай аагтай өнгөн болох; *боршсон шөл; цай борших.* *ᠪᠣᠷᠰᠢᠬᠤ*

**БОРШИХ II** бор өнгөтэй болох, борлох. *ᠪᠣᠷᠰᠢᠬᠤ*

7. Хэд хэдэн салга утгатай толгой үгийг бүх гол утгаар нь тайлбарлаж, утга тус бүрийг цэг бүхий араб тоогоор ялгавч

**ДУРСГАЛ 1.** ач тус, хайр нөхөрлөлийн илэрхийлэл; *дурсгалын хөшөө; дурсгал болгон үлдээх; дурсгалын хурал; дурсгалын тэмдэг; дурсгал болгох;* 2. өнгөрсөн үеийн өв сөёлоос үлдсэн зүйлс; *бичиг дурсгал; эдийн дурсгал; хөшөө дурсгал;* 3. дургал, *ᠳᠤᠷᠰᠠᠯ*

8. Гагцхүү холбоо үгээр хэрэглэдэг үг байвал тайм үгийн эхний үгийг толгой гарган, хойно нь давхар цэг тавьж тайлбарласан. Жишээлбэл:

**АЛДАГ:** алдаг оног хааяа, заримдаа; *ажилдаа алдаг оног очиж байна.* ᠠᠯᠳᠠᠭ

9. Хэвшмэл хэллэгийн тайлбарыг дан хаалтанд хийсэн. Хэрэв хэвшмэл хэллэгт хэд хэдэн салаа утга байвал а. б. в. гэх мэтчилэн үе-гээр дугаарлан салгаж тайлбарласан. Жишээлбэл: **ам дордойх** (садан төрлийн хүмүүсийн хоорондоо бага зэрэг хэрэлдэж муудалцах; *ам дордойвч элэг дордойхгүй хууч*); **амь бөхтэй** (а. хялбар үхдэггүй гэсвэртэй; б. хялбар урагддаггүй эд, эдэлгээ сайтай, яс чанар сайтай, в. хялбар ангижрахгүй зуунги; *өнгөрсөн нийгмийн үлдэгдэл манай ажил дээр амь бөхтэй оршиж байна*).

10. Хоршоо үгэнд х о р ш. гэж заалт хийсэн. Жишээлбэл:

**ИДЭВХ** мэриймж, чармайлт, санаачлага, мэрийлт; *идэвх гаргах; идэвх сайтай; идэвх хичээл; идэвх зүгэл х о р ш.* ᠶᠳᠡᠪᠬᠡ

11. Толгой үгэнд багтах дагалдах үгсийг нхэнхлээ эхний үгээр нь баримталж үүр болгон арай дэлгэр тайлсан. Жишээлбэл:

**ЗУД** гол төлөв байгалийн эрхшээл нөлөөнөөс болж, хүн малын идэш ууш нэн ховордож нийтээр маш их гачигдал үзэх цаг үе; **зуд гачиг**, **зуд турхан х о р ш.**; **ган зуд** (зуны цаг хур бороогүйгээс болж газар хэтэрхий гандаж гачигдах цаг үе); **хар зуд** (өвөл нас огт орохгүй, хараар хүйтэрч гачигдах цаг); **нагаан зуд** (өвөл маш их нас орж гачигдах цаг); **өлөн зуд** (идэш уушны зүйл маш ховор цаг); **зуд болох** (ган гачиг тохиох буюу нас шуурга хэтийдэж хүн мал зүдэж сүйдэхэд хүрүүлэх нөхцөл учрах); **зудтай тэмцэх** (зудад нэрвэгдсэн хүн малд туслах); *зуд болоход нохой таргалдаг, зовлон болоход лам таргалдаг зүйр.* ᠵᠠᠳ

Бас ч эцсийн үгийг баримталж зарим үгийг үүр болгосон нь уг толь бичигт буй бөгөөд толь ашиглагчдын хэрэгцээг бодож эхний болон эцсийн үгийг баримтлан үүр болгосон үгсийн аль алинд тайлбарласан буюу эсвэл нэгийг тайлбарлан нөгөөг тайлбарлаагүй.

12. Нэг юмны биеийн олон нэрийг, **гол нэрийг** дагуулан үүр болгож тайлбарласан. Жишээлбэл:

**МАЙХАН** бөс даавуугаар хийсэн, мочон багана нуруутай оромж, хэлбэр байдал янз бүр; **майхан шаах**, **майхан тагах** (майхан барих); **майхны ам** (майхны үүд); **майхны ваадан** (майхны ам талыг нээх зөрүүлэх хоёр хошуу); **майхны нуруу** (хоёр баганын дээд үзүүр дэх сэнжинд тогтоох урт мод); **майхны шувуу** (майхны багана); **майхны гол** (майхны их биеийн хоёр талын хэц); **майхны сүүл** (майхны бөгсөн этгээдийн нарийн үзүүр); **майхны хаяавч** (майхны хаяа тойрон хийсэн унжлага бөс); **майхны хэц** (майхны олон уулзарт бэхлэн хийсэн оле дээс); **майхны шанаа** (майхны хоёр голын хойд урд хоёр хошуу). ᠮᠠᠶᠢᠬᠠᠨ

13. Хэрэв хэвшмэл хэллэгийн зүйл үгийн хэд хэдэн салаа утгын аль алинд тохирохгүй байвал тус үүрийн эцэст \* тэмдэг тавьж тайлбарласан. Жишээлбэл:

**ГАНЦ** 1. бусадтай хамтраагүй, нэгээрээ, нэг, өрөөсөн; *ганц бие хүн; хүний ганц хүү; уналгын ганц морь; ганц нэг; ганц хүний суудалтай; ганц хүний ор; ганц хүн хүн болдоггүй, ганц мод гал болдоггүй*

з үй р; ганц бөхтэй тэмээ а м ь т а н (Африк, Азийн зарим оронд байдаг тэмээ, сүү ихтэй, аян жинд хэрэглэнэ); 2. зөвхөн, онцлон тусгайлсныг өгүүлэхэд хэрэглэх үг; *ганц малын ажил хийдэг; ганц хүссэн минь тэр; ганц би биш*; ☆ ганц хуруутах (хуруунд юм гарч идээлэн буглах).

ᠭᠢᠯᠠᠨᠴᠢᠨ

14. Толгой үгэнд нэр үгийг ганц тооны хэлбэрээр бичсэн боловч олон тооны хэлбэр нь хам олны утгыг илтгэсэн бол тийм үгийг толгой үг болгосон. Жишээлбэл:

**БАГАЧУУД** бага насны хүүхэд, залуучууд.  $\text{ᠪᠠᠭᠠᠴᠢᠭᠦᠳᠦ}$

**БАГАЧУУЛ** багачууд.  $\text{ᠪᠠᠭᠠᠴᠢᠭᠤᠯ}$

15. Нэр үгийг нэрлэхийн тийн ялгалын хэлбэрээр бичсэн.

16. Үйл үгийг үйлт нэрийн ирээдүй цагийн хэлбэрээр бичсэн. Мөн үйл үгийн ихэнх хэв байдлыг оруулсан. Зарим адил дуудлагатай үйл үгийн адил дуудлагатай хэвийг ихэнхдээ бөөгнөрүүлэн оруулсан.

17. Толь бичигт дагавар үг, дагавар үг, төлөөний үг, дэс хам тоо, аялга үг, холбоос үг, сул үгийн зүйл орсон бөгөөд тэдгээр үгсийн айг заасан заалт хийгээгүй.

18. Тус толь бичигт хэрэгцээгүй гэж үзээд оруулаагүй үгс: тийн ялгалын болон хамаадахын дагавартай үгс; үйл үгийн захирах хүсэх, цагийг заах хэлбэр, нөхцөл үйлийн хэлбэр, үйлт нэрийн ирээдүй цагийг заах, үйлийн эзнийг заах хэлбэрээс бусад хэлбэрүүд, товчилсон нэрс.

19. Үгийн эцсийн тогтворгүй «И»-тэй үгсийн «И»-г дангаар буюу эсвэл жийрэг эгшигийн хамт, бас тогтворгүй «И» залгасан толгой үгийн үндэс өөрчлөгдөх болбол өөрчлөгдсөн хэлбэрийг хаалтанд бичив. Жишээлбэл:

**МӨНГӨ (Н)** 1. цагаавтар өнгөтэй, өнгөлөг үнэт төмөрлөг; *алт мөнгө, мөнгө төгрөг, мөнгөн санхүү хорш*; 2. мөнгөлсөн юм; *мөнгөн аяга; мөнгөн хэт хутга; мөнгөн хазаар*.  $\text{ᠮᠥᠩᠭᠦ}$

**ЗУРАГЧ (ИН)** зураг зурах буулгахад мэрэгжилтэй хүн; *гар зурагч; уран зурагч; гэрэл зурагчин*.  $\text{ᠵᠤᠷᠠᠭᠴᠢᠨ}$

**АРАВ (АРВАН)** 1. тооны нэр; *ес дээр нэгийг нэмэхэд арав болно; хүний хоёр гарын хуруу нийлж арав болно; арав арваар; арван арав зуу; арван хоног; нэгдүгээр сарын арван*...  $\text{ᠠᠷᠪᠠᠨ}$

20. Нэг үгийн хэдэн янз бичлэгийн аль алийг бичиж, тайлбарыг нэг дээр нь бичсэн.

21. Орчин цагийн бичгийн хэлэнд хэрэглэгддэг нэг үгийн өөр өөр хэлбэрийг нөмийг оруулсан.

**ГУЙЛАНЧИН** 1. гуйдаг этгээд; 2. хөрөнгө ядуу.  $\text{ᠭᠤᠢᠯᠠᠨᠴᠢᠨ}$

**ГУЙЛГАЧИН** гуйранчин.  $\text{ᠭᠤᠢᠯᠭᠠᠴᠢᠨ}$

**ГУЙРАНЧ (ИН)** 1. хөрөнгө хогшил юу ч үгүй ядуу хүн; 2. гуйж амьдрагч.  $\text{ᠭᠤᠢᠷᠠᠨᠴᠢᠨ}$

22. Толь бичигт «Үз», «Хар» гэсэн заалт үг оруулаагүй бөгөөд харин үзвэл зохих үгийг тухайн үгийн ард шууд бичсэн.

23. Уг толь бичигт харь хэлнээс зээлдэн авсан үгийн өргөлтийг тэмдэглээгүй. Жишээлбэл:

АГМН 1. улсын зэвсэгт хүчин; *Зөвлөлийн арми*; 2. хэд хэдэн корпус, дивизээр бүрдсэн цэргийн том анги нэгдэл; *армийн генерал* (цэргийн цол). ᠑᠙᠓᠐

Бас орос хэлээр дамжиж монгол хэлнээ орсон үгст, орос хэлний У (Ү)-г одоогийн үсгийн дүрмийг баримтлан монгол хэлний У үсэгт багтаан оруулсан. Жишээлбэл:

**БУРЖУЙ** буржуйлиг ангид хамаарагдах дарлагч этгээд. ᠪᠦᠷᠵᠡᠢ

24. Тус толь бичигт үгийн гарлыг тэмдэглээгүй.

25. Тус толь бичигт орсон үсгийн хэрэглэх байдлыг тодорхой болгохын тулд толгой үгийн ихэнхэд жишээ дагалдуулж, зарим жишээнд зүйр, хууч, (үлгэр), (ерөөл) гэх мэтчилэн ишлэл заалт хийсэн.

26. Тус толь бичигт үсгийн сангийн судлалын зарим хэрэгцээтэй гэж үзэж хийсэн заалтуудыг чигжээтэй үсгээр бичсэн. Жишээлбэл: шилжсэн, бичиг, хуучирсан, яриа, шоодсон, ургамал, амьтан, зурхай, шашин гэх мэт.

27. Хуучин толь бичигт буй ургамал, амьтны нэр томьёог орос, хятад толиор уламжлуулан олдсоныг язгуур, нам, баг зэргийг зааж тайлбарласан. Олж чадаагүй заримыг хуучин тайлбарыг баахан засч оруулсан.

28. тус тольд орсон үсгийг эдүгээ БНМА Улсад хэрэглэж байгаа үсгийн дүрмийг баримталснаас гадна орчин цагийн бичгийн хэлийг хуучин монгол бичгийн хэлтэй харьцуулан судлахад зориулан толгой үгэнд хуучин монгол бичиг хадмалласан болно.

#### МОНГОЛ ЦАГААН ТОЛГОЙ

Аа	Бб	Вв	Гг	Дд	Ее	Ёё
Жж	Зз	Ии	Йй	Кк	Лл	Мм
Нн	Оо	Өө	Пп	Рр	Сс	Тт
Уу	Үү	Фф	Хх	Цц	Чч	Шш
Щщ	Ъъ	Ыы	Ьь	Ээ	Юю	Яя